



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 14 өдөр

Дугаар А/33

Ховд

Зарим арга хэмжээг түр
хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1.13, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалт, аймгийн Онцгой комиссын Шуурхай штабын хуралдааны 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст халдвар (covid-19)-ийн цар тахлын өвчлөл нэмэгдэж байгаатай холбогдуулан аймгийн нутаг дэвсгэрт зохион байгуулах спорт, соёл урлаг, тэмцээн уралдаан, сургалт болон олон нийтийг хамарсан арга хэмжээг 2022 оны 01 дүгээр сарын 15-ны өдрөөс 02 дугаар сарын 07-ны өдрийг хүртэл хугацаанд танхимаар зохион байгуулахыг түр хориглосугай.

2. Захирамжийг олон нийтэд мэдээлж, сурталчлан, хяналт тавьж ажиллахыг Баруун бүсийн төв-Ховд аймгийн Онцгой байдлын газар (хурандаа Б.Алтанбадралт), аймгийн Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа Д.Мөнхболд), Мэргэжлийн хяналтын газар (П.Эрдэнэчулуун), сум, байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлагуудад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ